



**МАЛЧДАД ЗОРИУЛСАН
ЗӨВЛӨМЖ**

МАЛЧДАД ЗОРИУЛСАН ЗӨВЛӨМЖ

Улаанбаатар хот
2019 он

ДАА 300

НАА 60

Я-324

Энэхүү зөвлөмжийг дахин хэвлэх эрх олгосон НҮБ-ын Хүнс, Хөдөө Аж Ахуйн Байгууллагад талархал илэрхийлье.

Эмхэтгэн боловсруулсан:

С.Жигжидсүрэн – Мал Аж Ахуйн Эрдэм Шинжилгээний Хүрээлэн

Д.Самданжамц – Монголын Мал Зүйч, Үржүүлэгчдийн Холбоо

С.Жигжидпүрэв – НҮБ-ын Хүнс Хөдөө Аж Ахуйн Байгууллага

О.Амартүвшин – Хүүхдийг Ивээх Сангийн ажилтан

© Гэрэл зургийн эрхийг Хүүхдийг Ивээх Сан эзэмшинэ.

ISBN 978-99973-0-917-4

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сан нь 1919 онд байгуулагдсан, хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгч, шашин, улс төрөөс ангид олон улсын бие даасан байгууллага юм.

Хүүхдийг Ивээх Сан нь нийгэм, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт, гамшиг, онцгой байдлын нөхцөлд болон урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад хүүхдийг хамгаалж, хүүхдийн эрхийг цогцоор нь хангахыг дэмжин ажиллаж ирсэн.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр нь 1994 оноос хойш монгол хүүхдийн амьдралд урт хугацааны, тогтвортой өөрчлөлтийг бий болгох зарчмыг баримтлан ажиллаж байна. Өнөөдрийн байдлаар хүмүүнлэг, боловсрол, хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн засаглал, эрүүл мэнд, хүүхдийн ядуурлыг бууруулах хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна.

Бид 1999 оноос эхлэн хүмүүнлэгийн яаралтай тусламж, эрт үеийн сэргээн босголт, гамшигийн эрсдэлийг бууруулах чиглэлээр ажиллаж ирсэн. Тухайлбал 2016, 2017 оны өвөлжилт, хаваржилтын хүндрэлд малчдын эрүүл мэнд, амьжиргааг хамгаалах, малчдын хүүхдүүдийн боловсролыг дэмжих чиглэлээр хүмүүнлэгийн буцалтгүй тусламж үзүүлэн ажиллаж ирсэн. Түүнчлэн 2018 оны 7-р сард тохиолдсон үерт их хэмжээгээр өртсөн, зорилтот бүлгийн гэр бүл, хүүхдүүдэд боловсрол, нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлэх төслийг 900 хүүхдийг хамруулан хэрэгжүүлж байна.

Энэ удаад бид өвөлжилт хаваржилтын хүндрэл үүсэхээс өмнө, бага малтай зорилтот бүлгийн малчин өрхийн амьжиргааг хамгаалах чиглэлээр урьдчилан сэргийлэх төслийг Баян-Өлгий аймгийн Баяннуур, Цэнгэл, Булган сум, Ховд аймгийн Эрдэнэбүрэн, Чандмань, Дарви, Мөст суманд тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Малчдад зориулсан энэхүү зөвлөмжийг бэлтгэхэд мэргэжлийн заавар зөвлөгөө өгсөн орон нутгийн Хүнс, Хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлэг үржлийн газрын удирдлагад талархал илэрхийлье.

АГУУЛГА

1.	Хүүхдийг Ивээх Сангийн тухай	5
2.	Зудын хүндрэлээс урьдчилан сэргийлэх төслийн тухай	7
3.	Малын хивгийг хэрэглэх заавар	8
4.	Зуд ба түүний ангилал	8
5.	Малчдын эрүүл мэндийг хамгаалах зөвлөгөө	9
6.	Хүүхэд хамгааллын зөвлөгөө	12
7.	Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандарт	14
8.	Мал сүргээ онд мэнд оруулах зөвлөгөө	15
9.	Бэлчээрийн зүй зохистой ашиглалт	17
10.	Байгалийн гэнэтийн аюулаас үүдсэн малын өвчнийг анагаах арга	18
11.	Ядарч доройтсон малыг сувилах, тэжээл бэлтгэх аргууд	19
11.1	Энгийн тэжээл бэлтгэх арга	20
11.2	Амьтны гаралтай тэжээл бэлтгэх арга	22
11.3	Жилбэггүй мал тэжээх арга	24
11.4	Төл тэжээх арга	25
11.5	Хөрөвжсөн төлийг тэжээх арга	29
11.6	Орон нутгийн нөөцөөр гар тэжээл бэлтгэх	30
12.	Хорогдсон малын сэг зэм устгах зөвлөмж	32

1. ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН ТУХАЙ

Хүүхдийг Ивээх Сан 1919 онд байгуулагдсан, хүүхдийн төлөөх үйлсээрээ дэлхийд тэргүүлэгч, шашин, улс төрөөс ангид олон улсын бие даасан байгууллага юм. Хүүхдийг Ивээх Сан нь нийгэм, улс төрийн нөхцөл байдлын өөрчлөлт, гамшиг, онцгой байдлын нөхцөлд болон урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх үйл явцад хүүхдийг хамгаалж, хүүхдийн эрхийг цогцоор нь хангахыг дэмжин ажиллаж ирсэн.



Хүүхдийг Ивээх Сангийн олон улсын эвсэл нь дэлхийн 120 гаруй оронд үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллага нь Монгол улсад 1994 оноос хойш хүүхдийн эрхийг хангах, хүүхэд хөгжүүлэх, тэдний сайн сайхан байдлын төлөө ажиллаж байна. 1994-2009 онд Английн Хүүхдийг Ивээх Сангийн, 2009 оноос Японы Хүүхдийг Ивээх Сангийн бүтцэд буй Монгол дахь хөтөлбөр нь хүүхдийн амьдралд

урт хугацааны, тогтвортой өөрчлөлт бий болгох зарчмыг баримтлан тулгамдаж буй асуудлуудад бодитой, системтэй шийдлийг олох арга зүйг эрхэмлэн ажилладаг. Японы Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр нь Боловсрол, Хүүхэд хамгаалал, Хүүхдийн эрхийн засаглал, Хүүхдийн Ядуурал болон Хүмүүнлэгийн хөтөлбөрүүдийг Улаанбаатар хот, Дорнод, Архангай, Өвөрхангай аймгуудад хэрэгжүүлж байна.

Бид 2015-2016, 2016-2017 онуудад Монголд тохиолдсон зудын гамшгийн нөхцөлд хүмүүнлэгийн яаралтай тусламж, эрт үеийн сэргээн босголт, эрсдэлийг бууруулах чиглэлээр 2016 онд 1,2 сая, 2017 онд 890,7 мянган ам.долларын санхүүжилт тус тус босгосон. Түүнчлэн 2018 оны 7-р сард тохиолдсон үерийн Баян-Өлгий аймгийн үерт өртсөн, зорилтот бүлгийн 4 айлд гэр, гэрийн хэрэглэл авахад нь дэмжлэг үзүүлж ажилласан. 133 мянган ам.долларын санхүүжилт босгон үерт өртсөн гэр бүл, хүүхдүүдэд гэрийн тусламж, боловсролын болон нийгэм сэтгэлзүйн дэмжлэг үзүүлж ажиллаж байна. Уг төслийн хүрээнд нийт 900 орчим хүүхэд, тэдний гэр бүлд хүрч ажиллаж байна. Хүмүүнлэгийн салбарт хүүхэд хамгаалал, боловсрол, хүнсний аюулгүй байдал ба амьжиргаа хамгаалах, эрүүл мэндийн чиглэлүүдээр ажилладаг. Түүнчлэн Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүүхдийн Сантай хамтран Монголын хүмүүнлэгийн багийн боловсролын бүлгийг удирдан ажиллаж байна.

Бидний алсын хараа: Хүүхэд бүр эсэн мэнд амьдрах, хамгаалуулах, хөгжих, оролцох эрхээ эдэлдэг ертөнцийг бий болгох;

Бидний эрхэм зорилго: Бодит дэвшил гаргах замаар хүүхдийн амьдралд эерэг нөлөө үзүүлж, тэдний амьдралд урт хугацааны өөрчлөлт авчрах

Хүүхдийг Ивээх Сангийн 2018 онд гаргасан амжилт, үйл ажиллагаануудаас дурдвал:

Хүмүүнлэгийн хөтөлбөр -Хүнд нөхцөлд буй малчин өрхүүд жил дараалан

тохиолдсон зудад өртсөнөөр амьжиргаагаа залгуулахад ихээхэн хүндрэл үүссэн төдийгүй зуд нь малчдын хүүхдүүдийн сэтгэлзүй болон боловсрол эзэмшихэд нь сөргөөр нөлөөлж байв. Тиймээс бид 863,500 ам.долларын хөрөнгө босгож малчин өрхүүдийн амьжиргааг хамгаалах, эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг цаг алдалгүй авахад нь туслах, хүүхдүүдийн сэтгэлзүйн, эрүүл мэндийн болон боловсролын хэрэгцээг хангах чиглэлээр ажиллалаа.

Боловсрол - 2015 оноос эхлэн хэрэгжүүлсэн нэгдүгээр ангийн сурагчдын суралцах чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх төсөл 2018 оны эхний улиралд амжилттай дууслаа. Нийслэлийн Баянзүрх, Чингэлтэй, Сонгинохайрхан дүүргийн ерөнхий боловсролын 24 сургуулийн бага ангийн 26,200 хүүхэд, 8,900 гаруй эцэг эх, 1,900 гаруй багшийг хамруулсан энэхүү төсөл сургуульд элсэгчдэд зонхилон тохиолддог бэрхшээлүүдийг багасгахын тулд сургуулийн бодлого, орчин, багшийн арга зүй, эцэг эхийн оролцоо, хамтын ажиллагааг сайжруулан тодорхой үр дүнд хүрлээ. Мөн оны 3 сараас эхлэн хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах зарчмыг дэмжих 3 жилийн төслийг эхлүүлсэн бөгөөд үүнд нийслэлийн ерөнхий боловсролын 6 сургууль, 3 дүүргийн Насан туршийн боловсролын төвүүд болон Өвөрхангай, Ховд аймгаас тус бүр 1 сургууль, Насан туршийн боловсролын төв хамрагдаж байна. Энэхүү төслийн хүрээнд тэгш хамран сургах боловсролын бодлогыг хэрэгжүүлэхэд чиглэсэн сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулна. Дээрх төслүүдийн санхүүжүүлэгч нь Япон улсын Гадаад хэргийн яам юм.

Хүүхэд хамгаалал -Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхэд хамгаалал хөтөлбөр нь хүүхдийг, ялангуяа хүнд нөхцөлд амьдарч буй хүүхдүүдийг хүчирхийлэл, дарамт, мөлжлөг, үл хайхрах явдлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлчилгээ үзүүлэх, аргазүйн дэмжлэг үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Хүүхэд хамгааллын тогтолцоог бэхжүүлэхэд чиглэсэн төсөл хөтөлбөр хэрэгжүүлж, Улаанбаатар хот болон Архангай аймгийн 9 сум, баг, хорооны хамтарсан багийн 165 гишүүдийн хүүхэд хамгааллын болон үзүүлэх үйлчилгээний талаарх ойлголт, мэдлэг нэмэгдсэн. Мөн хүмүүжлийн эерэг аргын цуврал сургалтуудад нийтдээ 324 эцэг, эх, асран хамгаалагчдыг хамруулж, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн ажлууд нь 82,704 хүн амын 19,715 өрхийн 28,637 хүүхдэд хүртсэн байна.

Хүүхдийн эрхийн засаглал -Хүүхдийн Эрхийн Засаглал хөтөлбөр нь НҮБ-ын Хүүхдийн Эрхийн тухай Конвенцийн хэрэгжилтийг үнэлэхэд эрх эдлэгч хүүхдүүд болон иргэний нийгмийн байгууллагууд, хүний эрхийн байгууллагуудын чадавх, үр дүнтэй оролцоог дэмжин, хүүхдийн дээд эрх ашгийг ханган хүүхдийн эрхийг хэрэгжүүлэх сайн засаглалыг бий болгон бэхжүүлэх зорилгоор үүрэг хүлээгч талуудыг мэдлэг мэдээллээр хангаж, хүүхдэд зориулах хөрөнгө нөөцийн хуваарилалтыг нэмэгдүүлэх чиглэлээр ажиллаж байна. Хүүхдийн ядуурлыг бууруулах -Бизнесийн боловсрол болон Энтрепренер ур чадвар олгох хөтөлбөрийг боловсруулан ажиллаж байна. Тус хөтөлбөр нь хүүхэд залуусыг өөртөө итгэлтэй, ухаалаг, бүтээлч

ирээдүйн бизнесийн болон нийгмийн манлайлагчид болоход дэмжлэг үзүүлэх зорилготой.

Эрүүл мэнд -Эрүүл мэндийн “Денан” төсөл нь Архангай аймгийн Тариат, Эрдэнэмандал сумын сум дундын эмнэлгүүдийн үйлчилгээг сайжруулж, орон нутгийн иргэдийн эрүүл мэндийг дэмжих зорилготой хэрэгжиж байна. Төсөл нь 6 дахь жилдээ хэрэгжиж, эрүүл мэндийн тоног төхөөрөмж, эмчилгээний материал нийлүүлэх, эмч бэлтгэх сургалт, хяналт-шинжилгээ үнэлгээ зохион байгуулах чиглэлээр ажиллалаа.

2. ЗУДЫН ХҮНДРЭЛЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТӨСӨЛ

2018.12.29-2019.02.11

Төсөл хэрэгжих орон нутаг:

Баян-Өлгий аймгийн Баяннуур, Булган, Цэнгэл сум
Ховд аймгийн Мөст, Дарви, Чандмань, Эрдэнэбүрэн сум

Төслийн зорилго: Зудын хүндрэлд өртөх өндөр эрсдэлтэй 831 малчин өрхийн амьжиргааг хамгаалах

Төслийн үйл ажиллагаа:

- Зудын хүндрэлд өртөх өндөр эрсдэлтэй 800 орчим малчин өрхөд малын тэжээлийн тусламж үзүүлэх замаар зудын хүндрэлээс урьдчилан сэргийлэх
- Дээрх өрх, тэдгээрийн хүүхдүүдэд зайлшгүй хэрэгцээт эд зүйлс худалдан авахад нь зориулж мөнгөн тусламж үзүүлэх
- Зудын нөхцөлд малчдын хүүхдийн боловсрол, эрүүл мэнд орхигдохоос сэргийлэх зорилгоор хүүхэд хамгаалал, боловсрол, эрүүл мэндийн гарын авлага тараах, мэдээлэл хүргэх
- Төслийн үр дүнгийн уулзалтыг Баян-Өлгий, Ховд аймаг болон Улаанбаатар хотод зохион байгуулж, төсөл хэрэгжүүлсэн туршлага сургамжийг холбогдох талуудтай хуваалцах

Хамтран ажиллах байгууллагууд:

- Баян-Өлгий, Ховд аймаг болон зорилтот сумдын ИТХ, ЗДТГ
- Баян-Өлгий, Ховд аймгийн Онцгой Байдлын Газар
- Баян-Өлгий, Ховд аймгийн Хүнс, Хөдөө Аж Ахуйн газар
- Баян-Өлгий, Ховд аймгийн Ус Цаг Уур, Орчны Шинжилгээний Газар
- Арилжааны банкны салбар тооцооны төвүүд

Төсөлд хамрагдах малчин өрхөд тавих шалгуур:

- Өөрийн мал сүргээ маллаж буй малчин өрх
- Хонин толгойд шилжүүлснээр 200 орчим толгой малтай
- Өрхийн эмзэг байдлын нэмэлт үзүүлэлтийг харгалзаж үзнэ.

Үүнд:

- Өрхийн орлого багатай эсэх
- Өрх толгойлсон малчин өрх эсэх
- Өрхийн 18 хүртэлх насны хүүхдийн тоо
- Өрхийн 18 хүрсэн, их дээд сургууль эсвэл мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд суралцаж буй оюутны тоо
- Өрхөд жирэмсэн болон хөхүүл эмэгтэй байгаа эсэх
- Өрхөд хөгжлийн бэрхшээлтэй болон эмнэлгийн байнгын хяналтад байдаг хүнд өвчтэй хүн байгаа эсэх
- Өрхийн өндөр настны тоо (55-аас дээш насны эмэгтэй, 60-аас дээш насны эрэгтэй)

Төсөлтэй холбоотой санал, хүсэлт хүлээн авах утас: 86294334
/ажлын өдрүүдэд 08:30-17:30/

3. ХҮҮХДИЙГ ИВЭЭХ САНГИЙН НИЙЛҮҮЛСЭН МАЛЫН ХИВГИЙГ ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Найрлага: Цардуул, уураг, аминдэм, E, B бүлгийн эрдэс бодис



Хэрэглэх заалт: Хивгийг давстай усаар чийглэж саалийн үнээнд 3-4 кг, бог малд 500-600 граммаар өгнө. Исгэсэн хивгийг дангаар нь буюу бусад тэжээлтэй хольж бод малд 1-2 кг, бог малд 300-400 граммаар өдөрт 1 удаа өгнө.

Хадгалах нөхцөл: Хуурай, сэрүүн нөхцөлд хадгална.

Анхааруулга: Тун хэтрүүлж өгөхөөс сэрэмжил. Залгиж, амьсгалахаас, мөн нүдэнд хүргэхээс болгоомжил. Хэрэглэсний дараа гараа угаана. Ахуйн хэрэглээний усны хангамжид хольж болохгүй. Хүүхдээс хол байлгана.

4. ЗУД БА ТҮҮНИЙ АНГИЛАЛ

Зуд гэдэг нь хүйтний улиралд цаг агаарын зохисгүй нөхцөлийн улмаас бэлчээрийн мал аж ахуй болон аймаг улс орны эдийн засаг нийгэмд ихээхэн хохирол учруулдаг байгалийн үзэгдэл юм. Зудыг эрчимжлээр нь “зудтай”, “зудархуу” гэж ангилна. Мал бэлчээрт өл залгаж чадахгүй болох шалтгаанаар нь зудыг цагаан, хар, туурайн, шуурган, төмөр буюу мөсөн зуд гэх мэтээр ялгана.

Намар хаврын цагт их хэмжээний цас орж, бэлчээрийн өвс цасаар хучигдсанаас мал бэлчээрээс өвс олж идэх боломжгүй болж, малын тэжээл

дутагдан мал олноор хорогдох нөхцөл бүрдэхийг цагаан зуд гэнэ. Цагаан зудын үед цас хайлж орох буюу орсон цас хайлж, хөрсөн дээр мөсөн бүрхүүл тогтоход бэлчээрийн өвс барьцалдан хөлдөж, мал цавчлаад ч өвс олж идэх аргагүй болдгоос гадна малын хөлийн үс, арьс халцрах, туруу нь ханзрах нөхцөл болдог.

Бэлчээрийн цасны нягт аль ч бүсэд 0.20-0.24 гр/см³, цасны дундаж зузаан өндөр уулын болон ойт хээрийн бүсэд 16 см, хээрийн бүсэд 11 см, говь, цөлийн бүсэд 5 см-ээс их байх нөхцөлийг цагаан зудархуу гэнэ. Зун нь гантай, гандуу байсан нутагт өвөл цас ороогүй, арав хоног, сарын дундаж агаарын температур олон жилийн дунджаас гурав болон түүнээс дээш хэмээр илүү хүйтэрч, мал ус, тэжээлээр дутагдах нөхцөлийг хар зуд гэнэ. Зун нь гантай, гандуу байсан нутагт өвөл цас ороогүй, арав хоног, сарын дундаж агаарын температур олон жилийн дунджаас хоёр болон түүнээс дээш хэмээр илүү хүйтэрч, мал ус, тэжээлээр дутагдах нөхцөлийг хараар зудархуу гэнэ.



Цаг зуурын дулаарал, хүйтрэлтийн улмаас цасны өнгөн хэсэг буюу гүнд мөсөн бүрхэвч тогтсоноос мал бэлчээрлэх боломжгүй болсон эсвэл цасны нягт 0.35 гр/см³ болон түүнээс их болсон нөхцөлийг төмөр буюу мөсөн зуд гэнэ.

5. МАЛЧДЫН ЭРҮҮЛ МЭНДЭЭ ХАМГААЛАХ ЗӨВЛӨГӨӨ

Гэр бүлийн гишүүдийн эрүүл мэндийн талаар:

Хүн бүр өөрсдийн болон гэр бүл, үр хүүхдийнхээ эрүүл мэндэд онцгой анхаарах нь чухал.

- Цаг агаарын байдлаас шалтгаалан үүсэх хүндрэл бэрхшээл, отор нүүдлийн үед дулаан хувцаслаж осгох, хөлдөхөөс сэргийлэх
- Ахмад настан, жирэмсэн, нярай хүүхэдтэй эхийг аль болохоор гэр болон төв суурин газарт байлгах, отор нүүдлээр явуулахгүй байх
- Эмнэлгийн яаралтай тусламж авах шаардлагатай тохиолдолд хамгийн ойрхон байгаа эмч, эмнэлэгт хүрч болох зам, харилцах утасны лавлах мэдээлэлтэй байх
- Тэжээллэг хоол идэх, хүүхдийг хөхөөр дагнан хооллох, бага насны хүүхэд болон жирэмсэн, хөхүүл эмэгтэйчүүдэд тэжээлийн бэлдмэлийг тогтмол хэрэглүүлэх
- Удаан хугацааны цасан шуургатай үед гэртээ орж гарч байх, хаалга үүд орчмын цасыг цэвэрлэж холтгож байх. Учир нь гэрийн хаалга онгойхгүй болж болзошгүй аюултай

- Хувийн ариун цэврийг сайтар сахих
- Үхсэн малын сэг зэмтэй болгоомжтой харьцан халдвар, хамгааллын дэглэмийг мөрдөж, халдваргүйжүүлэлт хийх
- Хөлдөх осгох тохиолдол гарвал:
 - Биеийн хөлдсөн хэсгийг хүйтэн усанд дүрэх, гэхдээ усны температур биеийн хөлдөөгүй хэсгийнхтэй ойролцоо байх, халуун усанд дүрэхийг хориглох
 - Хэрэв гарын сарвуу хөлдсөн бол гарыг зөрүүлж суганы хонхорт байрлуулж бүлээцүүлэх
 - Арьс эрхтнийг гэмтэхээс сэргийлж, хөлдсөн хэсгийг цасаар арчих, иллэг хийхийг хориглох
 - Бигнүүр, халуун гэрэл цахилгаан болон ханан зуухаар дулаацуулахыг хориглоно.

Жирэмсэн эмэгтэйчүүдэд зориулсан зөвлөмж

Жирэмсний эхний 3 сарын дотор эмчийн хяналтад орох нь чухал юм. Жирэмсний хяналтад цагтаа орох нь дараах ач холбогдолтой:

- Төрөх хугацааг үнэн зөв тогтоох
- Шинжилгээнд хамрагдах
- Мэргэжлийн эмч нарт үзүүлж, эрүүл эсэхээ мэдэх
- Ямар нэгэн өвчин илэрвэл эмчлүүлэн эрүүлжих
- Хэвлий дэх ургийнхаа өсөлт хөгжилтийг хянах
- Тохиолдож болох хүндрэлүүдээс урьдчилан сэргийлэх, хүндрэл гарсан үед хугацаа алдалгүй тусламж авах
- Жирэмсэн үеийн дэглэм, төрөлтөд бэлтгэх, нярайг асрах талаар мэдлэгтэй болох
- Жирэмсний хугацаа, жирэмсний амралт авах

Жирэмсний үед доорх эмгэг, аюултай шинжүүд илэрвэл яаралтай эмчид хандаарай.

- Толгой өвдөх
- Дотор муухайрах
- Амьсгаадах
- Биеийн жин нэмэгдэхгүй байх эсвэл 7 хоногт 400 граммаас дээш нэмэгдэх
- Хэвлийн доод хэсгээр базалж өвдөх
- Нүд бүрэлзэх
- Нүдний өмнө оч гялалзах
- Чих шуугих
- Хавагнах
- Шээсний гарц багасах
- Арьс салст гэнэт цайх

- Хүүхэд хөдлөхгүй байх
- Үтрээнээс цус эсвэл ус гарах

Нярайн асаргааны зөвлөгөө

- Төрсний дараах амьдралын 28 хоногийг нярай үе гэнэ. Эхийн цусан дахь даавар нярайд дамжсанаар эр, эм нярайн хөх хавдаж, зарим тохиолдолд сүү гардаг нь хэвийн үзэгдэл бөгөөд эмчилгээ шаарддаггүй. Хөх үрэвсэх магадлалтай учир хөхийг сааж болохгүй.
- Гэрт гарснаас хойш хүйг хуурай цэвэр байлгаж, юу ч түрхэхгүй байх үндсэн зарчмыг баримтална. Хүйг агаарт ил, боолтгүй байлгасан нөхцөлд 2 долоо хоногийн дотор хатаж унадаг.
- Нярайн биеийн дулаан зохицуулалт тогтворжоогүй байдаг тул түүнийг дааруулахгүй дулаан байлгах нь чухал ач холбогдолтой.
- Нярайн арьс чийглэг, хуурайшаагүй, хүүхэд дулаанаа барих чадвартай болсон тохиолдолд өдөр бүр, бусад тохиолдолд 7 хоногт 3 удаа буюу өнжөөд усанд оруулж болно.
- Хүүхдийн нүүрийг өдөр бүр буцалсан бүлээн усаар угаана. Чихний ар, хүзүү, суга, цавь зэрэг амархан нурдаг хэсгийг өдөр бүр шалгаж, хүүхдийн зориулалтын тос, цацлагын аль тохирохыг хэрэглэнэ.

Сэтгэл зүйн зөвлөгөө:

- Сэтгэл санааг тогтвортой байлгаж, тохиолдож байгаа бэрхшээлийг айл хөрш, ах дүү, орон нутгийн захиргааны болон тусламж дэмжлэг үзүүлэхээр ирсэн хүмүүст ярьж, зөвлөгөө авах
- Өөртөө үүсч байгаа сэтгэл зовнил, түгших, айдас хүрэх, зүрх дэлсэх, толгой өвдөх, алга хөлрөх, амьсгаа давхцах, ходоод орчим өвдөх зэрэг зовиурын үед бусдад сэтгэлээ илчлэн ярьж байх. Энэ үед архи буюу тайвшруулах эм хэрэглэхээс аль болох зайлсхийх.
- Хүүхдүүд болон гэр бүлийнхэн, ойр дотнын хүмүүсээ тайвшруулж, тэдний яриаг сонсох, болсон явдлын талаар ярилцах, ялангуяа хүүхдэд төрж буй айдас харамслын сэтгэлийг сарниулах, тэдэнд урмын үг хэлэх, тэднийг зоригжуулан сэтгэлийн дэм өгөх.
- Хүүхдүүд болон гэр бүлийнхэн хамтдаа байх, хамтарч аливаа зүйл хийх, хамгийн гол нь бие эрүүл, ухаан саруул байхад бүхнийг даван туулж чадна гэх итгэлийг бие биедээ өгч байх

Малчны аюулгүй байдлыг хангах талаар:

- Боломжтой бүх аргаар түлшний мод, нүүрс, аргал, хөрзөн нэмж нөөцлөх
- Бага насны хүүхдийг малын хариулга маллагаанд явуулахгүй байх
- Цаг агаарын мэдээ, мэдээллийг тогтмол ашиглан, цаг агаарын тааламжгүй үед мал сүргээ ойрын бэлчээрт хариулах
- Найдвартай унаа, морь тээврийн хэрэгсэл байнга бэлэн байлгах

- Хүрз, зээтүү, жоотуу, царил, гаапуу зэрэг багаж хэрэгслийг бэлэн байлгах
- Шаардлагатай үед хүн малд тусламж үзүүлэх эмийн сантай байх
- Өрхийн хэмжээнд нэгээс доошгүй гар утсыг байнгын ажиллагаатай байлгах

6. ӨВӨЛЖИЛТИЙН ХҮНДРЭЛ, ЗУДЫН НӨХЦӨЛ БАЙДАЛД ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН ЗӨВЛӨГӨӨ

Зуд бол манай оронд нийтлэг тохиолддог байгалийн гамшгийн нэг төрөл юм. Зуд болоход ихэнхдээ малчид болон малд анхаарал хандуулдаг. Гэвч зуд хүүхдэд сөрөг нөлөө учруулж болохыг бид тэр бүр анзаардаггүй.

Зуд болоход ялангуяа аймаг, сумын төвд сургуульд суралцаж байгаа малчдын хүүхдүүд “Аав ээж хэр байгаа бол, мал сүрэг мэнд байгаа болов уу, цас их орж байгаа болов уу, зам хаагдсан болов уу, түлээ хангалттай байгаа болов уу, хэрвээ бүх малаа алдчихвал цаашдаа яаж амьдарна аа, надад зүсэлж өгсөн хурдан үрээ минь зүгээр байгаа даа” гэх мэтээр олон зүйл бодож, санаа зовж, шаналж байдаг.

Ийнхүү сэтгэл санаа нь таагүй, шаналж буй хүүхэд хичээлдээ анхаарлаа хандуулъя гэсэн ч чадахгүй бөгөөд улмаар хичээлдээ хоцрогдох, сурлага муудах, хичээлдээ сонирхолгүй болох, бүр цаашилбал сургууль завсардаж ч болзошгүй. Түүнчлэн зарим малчдын хувьд хүүхдэдээ тавих анхаарал суларч, үүнээс үүдэн хүүхэд хэрэг төвөгт холбогдох, хүчирхийлэлд өртөх зэрэг сөрөг үр дагавар гарах эрсдэл нэмэгддэг. Зөвхөн малчдын хүүхэд гэлтгүй бусад хүүхэд ч гэсэн даарах, даарснаас болж өвчлөх нь ихэсдэг.



Зудын үед хүүхдийг хэрхэн хамгаалах вэ?

- Дулаан хувцаслах
- Тэжээллэг хоол хүнсээр хангах
- Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээг тогтмол хүлээн авч, хэрэглэж хэвших
- Хүүхдийг ялангуяа бага насны хүүхдийг гэрт нь ганцааранг нь үлдээхгүй байх
- Хүүхдийг мал, малын эрэл болон бусад зүйлд явуулахгүй байх
- Хүүхдэд, ялангуяа гэрээсээ хол байгаа хүүхдэд сэтгэлзүйн анхны тусламж үзүүлэх, гэр рүүгээ дур мэдэн явахаас урьдчилан сэргийлэх, сургуулиас завсардахгүйгээр суралцахад нь анхаарах
- Өөртөө болон бусдыг хамгаалах мэдлэг, чадвар, дадлыг хүүхдэд эзэмшүүлэх
- Байгалийн гамшгийн талаар хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон богино хэмжээний сургалтад хамруулах
- Хүүхдийн чөлөөт цагаа зөв өнгөрүүлэхэд илүү анхаарах, тэдэнд зориулсан чөлөөт цагийн арга хэмжээ, сургалт тогтмол зохион байгуулах

Хүүхдэд сэтгэлзүйн анхны тусламж хэрхэн үзүүлэх вэ?

Зуд болоход ар гэрийнхэндээ санаа зовж, сэтгэл нь шаналж байгаа хүүхдүүд дараах хариу үйлдэл үзүүлж болно. Үүнд:

- Айх
- Сандрах
- Уйлах
- Орондоо шээх
- Шөнө нойрондоо муудах, зүүдлэх
- Гэнэт халуурч, өвдөх
- Уурлах, бухимдах
- Гутарч шаналах
- Анхаарлаа төвлөрүүлж чадахгүй байх
- Тоглохоо болих, тоглох нь багасах
- Дуугаа хураах, ярихгүй байх
- Бодолд дарагдах
- Найзуудаасаа хөндийрөх
- Түрэмгий авирлах
- Хөдлөх дургүй болох
- Томчуудын үгийг тоохоо болих
- Дотуур байрнаасаа оргохыг завдах
- Хичээлдээ дургүй болох, шалтгаангүйгээр хичээл таслах гэх мэт

Хүүхдэд дээрх хариу үйлдэл илэрвэл эцэг эх, асран хамгаалагч, багш, хөрш, найз та бүхэн түүнтэй ярилцан, сэтгэл санааг нь “эмчлээрэй”. Ингэхдээ дараах гурван шат бүхий зарчмын дагуу туслаарай:



Хүүхдүүдийг сайтар ажиглан харна. Өлсөж, цангаж, даарч байгаа эсэх, гэрээ санан уйлж байгаа эсэх, унтаж чадаж байгаа эсэх, хоолоо тогтмол идэж байгаа эсэх, найзуудтайгаа тоглож байгаа

эсэх, гэрийнхэнтэйгээ холбоо тогтоож чадаж байгаа эсэх, хичээлээ ойлгож байгаа эсэхийг нь ажиглана.



Хүүхэд юу ярьж байгаа, түүнд юу хэрэгтэй байгааг сайн сонсож, чин сэтгэлээсээ ярилцана.



Шаардлагатай бол хүүхдийг эмч, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчтэй уулзуулах гэх мэтээр мэргэжлийн хүн, байгууллагатай холбоно.

Шаардлагатай тохиолдолд дараах утсанд хандаарай!

Утасны дугааруудын өмнө орон нутгийнхаа кодыг оруулахыг анхаарна уу.

- 101-Гал түймэр
- 102-Цагдаа
- 103-Түргэн тусламж
- 105-Гамшиг, осол
- 108-Хүүхдийн утас
- 109-Малчин лавлах

7. МАЛ АМЬТАНД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНД БАРИМТЛАХ ЗААВАР, СТАНДАРТ

Малын тоо толгой цөөлөх

Онцгой байдлын үеийн Мал амьтанд чиглэсэн үйл ажиллагаанд баримтлах заавар, стандартад мал сүргийг худалдан борлуулах, нядлах, нядалж устгах замаар тоо толгойг нь бууруулахыг санал болгосон байдаг. Зуны цагт уур амьсгал, хур тунадас бага орсноос үүдэн бэлчээрийн гарц муудаж, өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал хүндрэх шинж төлөв ажиглагдсан үед малчид эртнээс худалдан борлуулах, нядлах мал сүргээ тооцож, бэлтгэл хангах нь малыг эдийн засгийн эргэлтэд оруулах, олсон орлогоо үлдсэн малдаа хадлан тэжээл бэлтгэх, отор нүүдэл хийхэд зарцуулахад чухал үүрэгтэй. Мөн ингэснээр сүргийн бүтцийн тэнцвэрийг хадгалж, бэлчээрийн даацаас гадна байгаль орчин, хүн амын эрүүл мэндийг ч болзошгүй эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой. Түүнчлэн зуд болохоос урьтаж, мал сүргээ тарилга вакцинд хамруулж, эрүүлжүүлэхэд онцгой анхаарах нь зүйтэй. Эрүүл мал ашиг шим өндөр, зун намрын цагт тарга хүч сайн авч, өвөлжилт, хаваржилтын хүнд нөхцөл байдлыг даван туулах чадварын хувьд харьцангуй илүү.

Малын усалгааг сайжруулах

Малчдын амьжиргааны үндэс суурь болсон мал хөрөнгийг онцгой байдлын үед хамгаалах чухал алхмын нэг нь мал сүргийг тогтмол усаар хангах явдал билээ. Мал сүргийн ундны эх үүсвэрийг тогтвортой хадгалахын тулд одоо ашиглаж буй худаг усаа сэлгэн сайжруулж, өвөл

хаврын цагт хөлдөөхөөс хамгаалж, давхар таг хийж болно. Шинээр худаг ус гаргах бол нүүдлийн мал аж ахуйгаар дамжиж ирсэн уламжлалт мэдлэг ухаанаас гадна, орчин үеийн техник технологи ашиглаж, шинжлэх ухаанч байдлаар хандвал дээр.

Хашаа хороо өтөг бууц бэлдэх

Нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн нь нэлээдгүй хувьд нь цаг зуурын байдалд тайвширч, урин дулаан цагт малын өвлийн хашаа хороогоо зэхэн, сэлбэж сайжруулан, өтөг бууц хангалттай бэлдэж, өнтэй өвөлжихийг төдийлөн ойшоодоггүй. Зарим залуу малчдын хувьд сарлагт үхэрт хашаа хороо хэрэггүй гэж үзэх нь ч бий. 2015-2016 оны өвөл хэд хэдэн аймгийг хамарсан зуднаар олон сарлаг хорогдсоны гол шалтгааны нэгээр малчид өвлийн хашаа бууцаа зэхээгүй, өвөлжилтийн бэлэн байдал хангаагүй байсныг нэрлэдэг. Малчдын хувьд гарын доорх эд материалаар малын хашаа хороо, саравч барих боломжтой байдаг нь нүүдлийн мал аж ахуйд том давуу талыг авчирна.

8. МАЛ СҮРГЭЭ ОНД МЭНД ОРУУЛАХ ЗӨВЛӨГӨӨ

а. Өвөлжөө, бууц болон хэвтрийг дулаан хуурай байлгах:

- Дулаан өвөлжөөнөөс аль болох нүүхгүй байх
- Хашаа хороог хунгар цасанд даруулахгүйн тулд саравчны ард 15-20 метрийн зайтай дарцаг, 3-4 давхар хаалт хийх, саравчны дээд талд хоорондоо 5-7 метрийн зайтай 3-4 дарцаг босгох / дарцагны хийсэлтийн нөлөөгөөр цас хол унадаг/
- Хонь хотлох хашааны дотор баруун, зүүн хойд хэсэгт нүх ухаж, хөлдсөн хоргол, нойтон шар бууц дүүргэн дарж овоолоод хонио хотлуулан хэд хоноход хөлдүү нь гэснэ. Энэ үед буцааж тараана. Бууцаар аль болох цөөхөн овоо хийвэл дулаанаа сайн барьж хатна. Бууц хатаах нүх нь 70 см гүн, өргөн, уртаараа нэг метр, хоорондоо 3-4 метрийн зайтай байна. Ийм нүхэнд хатаасан бууц 16-18 метр.кв талбайд хүрэлцдэг.
- Цас ихтэй үед салхины зонхилох чиглэлийн дагуу хоорондоо 10 метрийн зайтай цасан хороо 2-3-ыг барьж, хаалт болгох
- Жавар ихтэй үед утаа, май тавьж, хашаа, пүнзний цан хүүргийг арилгах зэрэгт анхаарах
- Хотны бууцыг овоолох, сүүдэр хэсэгт халуун үнс хуурай бууц хоргол асгах, мал хотноос гарсны дараа хэвтрийг бүтээх, хотон дотор утаа май тавих зэргээр хөлдөөхгүй байж болно. Мөн хотныхоо голд урт өргөнөөрөө 1.5-2 метр, гүнээрээ 1 метр орчим нүх ухаж, хөлдүү хоргол хийгээд хуурай бууцаар хучиж, малаа дээр нь хотлуулахад хөлдүү хоргол 24-48 цагт малын илчинд халж хатдаг байна.

б. Мал, маллагааны талаар:

- Малыг халуун хэвтрээс нь хөөж тууж гаргах бус харин хөдөлгөж хашаанд нь түр байлгасны дараа тааваар нь гаргах
- Хүчтэй хүйтэн цасан шуурганы үеэр хотонд байгаа малын нүд цантдаг. Малын нүд цантах нь мал уруудах нэг шалтгаан болдог. Малын нүд цантсан эсэхийг харж анзаарч байх, цанг арилгах
- Гэрүүдээ чандамлан барих буюу тэрэгний арлуудыг босгож, хашаа дамжуулан тавьж, берзинт нөмрөгөөр саравч хийх, малаа уруудахаас хамгаалах
- Дальпууг ашиглан бэлчээрийн зам гаргахаас гадна өвс сайтай бэлчээрийг хамгийн түрүүн гаргаж ашиглах
- Цас ихтэй газрын бэлчээрийг адуу бэлчээж, хөрлөсөн цасыг задлах
- Малаа нөмөр газар бараадуулан хариулах

в. Малын усалгаа:

- Муудсан малыг бүлээн усаар усалж байвал тэнхрэх нь амархан байдаг
- Сувилж тэжээж байгаа малыг услахдаа 1 литр бүлээн усанд амны халбага давс уусгаж услах
- Өвөл тэжээж буй малыг услах хэмжээ нь зуны улиралд услах хэмжээнээс 2 дахин бага байдгийг анхаарах
- Малд хүчит тэжээл өгөхөөс өмнө заавал усалсан байх, тэжээлийг урьдчилж дэвтээх шаардлагатай

г. Малд амин дэм ихтэй сувиллын шингэн болон эрдэс тэжээл өгөх:

- Тэжээж байгаа малын байр хот, хороог байнга хуурай дулаан байлгах
- Тэжээх малд хивлэг үүсгэх зорилгоор бага боловч бүдүүн тэжээл өвс өгөх
- Тэжээлийн хүрэлцээ хангамжаас шалтгаалан малыг сонгож тэжээх

д. Осгож сульдсан малыг тэнхрүүлэх:

- Осгосон малыг гэнэт дулаан байранд оруулж болохгүйг анхаарах
- Юуны өмнө сэрүүн газар оруулаад битүү хучиж, шар тостой хар цай 100-150 граммаар нэг цаг эсвэл 30 минутын зайтайгаар босч ирэх хүртэл өгнө. Үүний дараагаар гүүний айраг бүлээтгэж, 400-500 граммаар өгөх, цай, сулхир, шар будааны зутан хийж өгч сэргээнэ

- Осгосон малд хүйтэн ус өгч биеийг үрж, дулаацуулан хучих, адууны махны шөл, шар тос, сонгино сармис өгөх
- Турж доройтсон малыг нэмнэх, нэмнэхдээ, хээл, хэвлий хэсгийг дулаалах
- Малын хөл, хошуу үс халцарч шархлахад хоромхон тос, эсвэл адуу, загасны тосыг хөөтэй хольж түрхэх

е. Мал дарагдаж хорогдохоос сэргийлэх:

- Малд дарагдахаас сэргийлэн хашаанд олон өрөө гаргах, хонь ямааг хольж хаших
- Малын байрыг шөнийн цагт гэрэлтүүлэгтэй байлгах
- Хашаандаа нүүрэвч хийх, өдөрт нүүрэвчийг сөхөж, нар салхи оруулж байх


9. БЭЛЧЭЭРИЙГ ЗҮЙ ЗОХИСТОЙ АШИГЛАХ ТУХАЙ

Монгол оронд мал аж ахуй эрхлэхэд хамгийн хүнд бэрх нь өвөл, хаврын улирал байдаг. Энэ нь барагцаалбал 180-210 хоног үргэлжлэх урт хугацаа юм. Өвөлжөө бол хатуу цагт итгэж нутаглах газрыг хэлэх ба нөмөр дулаан, бэлчээр сайтай, харз, ус, гар худаг, цастай газрыг сонгон өвөлжиж, хаваржин хатуу цагт мал, төлийн гарзгүй байхыг эрхэмлэнэ.

Бэлчээрийг алсаас дотогш хумьж ашиглах нь зөв юм. Улирал дотроо бэлчээрийг сэлгэж ашигладаг. Нутаг сэлгэн нүүх нь малаа шинэ соргог бэлчээрт ойртуулах, ашигласан бэлчээрийг амраах, нөхөн сэргээх болон хэт талхлагдаж бохирдохоос хамгаалах зэрэг ач холбогдолтой байдаг.

Бэлчээрийн даац тохируулах, малын хариулга маллагааг зөв хийх замаар бэлчээрийг зохистой ашиглах нь зүйтэй. Бэлчээрийн даацаас хэтэрсэн малаа эдийн засгийн эргэлтэд оруулах буюу эр сувай малыг бордох, заазлах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай. Зун, намрын улиралд тэжээх малын тоо, ашиг шимд тохируулан хадлан, тэжээлээ базаах нь хамрын улирлыг эрсдэл багатай даван урьдчилсан нөхцөл болдог. Мөн баруун бүсийн малчдын хувьд таргалахад ташуур, турахад тушаа болдог байгалийн давс, хужрын нөөцийг бэлтгэх боломжтой байдаг.

Сүргийн бүтэц гэдэгт тухайн төрлийн малын дотор түүний нас, хүйсийн бүлэг тус бүрийн эзлэх хувийн жинг ойлгоно. Өөрөөр хэлбэл жилийн аль ч хугацаанд сүргийн зохистой бүтцийг барьж чадвал тухайн төрлийн мал аж ахуйгаас хамгийн их хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой гэсэн үг.



Зураг 1. Өвөл, хаврын улиралд бэлчээрийг зүй зохистой ашиглах бүдүүвч

10. БАЙГАЛИЙН ГЭНЭТИЙН АЮУЛААС ҮҮССЭН МАЛЫН ӨВЧИН ЭМГЭГИЙГ АНАГААХ АРГА

Шээс хаагдах: Хонь, ямаа, үхрийн шээс хаагдах нь элбэг тохиолдоно. Энэ нь хөлдүү хэвтэр, бууц дээр доороосоо хайрагдаж, даарснаас шалтгаалдаг гэж үздэг. Шээс нь хаагдсан малд зовиурлах, байн байн сүүлээ өргөж дүлэх, хэвтэх, босох, тогтворгүй болох, явахдаа сүүлээ моодойлгон өргөж явах, алцганах, шээсээ дуслуулах шинж тэмдэг илэрнэ. Шээс хаагдаад удсан тохиолдолд шалан, салтаа, чив хавдах, босож чадахаа больж, халуурах болно. Эцэж ядарснаас болж шээс нь хаагдсан бол ясны шөл, шар будааны шүүс хэдэн литрийг өгнө. Мөн өтгөн хар цай, яс, махны шөл өгнө. Шалан, чив, салтаа орчимд халуун жин тавина.

Шилбэний үс, арьс халцрах: Малын шилбэний халцархайг цэвэрлэж, аргалын үнсээр арчиж хатаагаад хоромхон болон адуу, тарвага, загасны тосыг хөөтэй хольж түрхэн гаднаа авч үлдэн 2-3 хоног тэжээхэд эдгэрнэ. Мөн даавуу, хөдөс зэргийг ашиглан шилэвч хийж, халцрахаас хамгаалж

болно. Өсвөр насны малын хамар амархан хөлддөг тул адууны өөх, тос, шар тос зэргийг түрхвэл хөлдөхгүй. Даарч бээрсэн мал цас идэж чадахгүй байсаар усаар дутагдаж үхэх явдал гардаг тул усан хангамжид анхаарч, бүлээн хар цай, давстай бүлээн усаар усалж байх хэрэгтэй.

Шарх: Цас зудтай үед мал хатуурсан цасыг хөлөөрөө цавчиж ухсанаас арьсны үс зулгарч улмаар шарх үүсдэг. Цус шүүрэх маягтай бага хэмжээтэй гарч байгаа бол үнс, бүлээн нурам цацаж үрдэг. Шарх нь эдгэхгүй удаж бохирдсон, идээлсэн бол ариутгагч уусмал эсвэл давстай хар цайгаар сайтар угааж цэвэрлээд аргалын цэвэр үнс цацна. Цус их гарч, арьс гүнзгий гэмтсэн үед боолт хийх шаардлагатай. Мөн шарханд гахай, баавгайн өөх, адуу, тарваганы тосыг дангаар буюу тогооны хөөтэй хольж түрхэнэ. Арц, гишүүний навч, үндсийг хатааж сайтар нунтаглаад шарханд цацна. Эдгээрийг тостой хольж шарханд түрхэн эмчилж болно.

Ширхтэх: Турж эцсэн мал сүрэгт ширхтэх өвчин нэлээд түгээмэл тохиолдоно. Хүйтний улмаас ширхэтсэн мал арц, мойл, аргалын үнс, улаан тамхи, хар шаваг, цагаан ортууз, зээргэнэ, өвсийг хатаагаад нунтаглаж малын биед цацаж түрхэнэ. Аргалын хөх үнсийг ширх, хүрд ассан хэсэгт түрхэхэд сайн нөлөө үзүүлнэ. Малын биеийн ширхэтсэн хэсэгт тарвага, адууны бүлээн тос түрхэж, улиас модны үнснээс ширхэтсэн газар цацаж болно.

Хүрдтэх: Малд хүрд хорхой шимэгчилсний улмаас ноос үс нь унаж халцран улмаар хүйтний улиралд даарч, турж эцэн үхэж хорогдоно. Бог малын бие дэх хүрд хорхой шимэгчилсэн хэсгийн бөөгнөрч хогжруутсан ноосыг гараар задалж, халуун нурмаар жигнэх эсвэл тэр хэсэгт нь ургамлын болон адуу, тарваганы халуун тос /50-60 градус/ хийж эмчлэхэд үр дүнтэй байдаг.

Мал, эцэж өөөдөх: Цас зудтай үед тарга тэвээрэг муутай мал эцэж ядарснаас хэвтэрт орж, эцэж өөөдөн босож чадахгүй болдог. Ийнхүү дор орсон малын бие ялангуяа үе мөчнүүд оршиж цаашид улам хүндэрнэ. Өөөдсөн малын арчилгаа, сувилгаа, тэжээлийг сайжруулан сувилахаас гадна газарт гал түлж, цог нурмыг зайлуулан халуун шороон дээр малаа хэвтүүлж босговол биеийн чилээ, оршоо гарч өөөдөхгүй болно.

Сархинаг хатах: Хар цагаан зудын үед болон хуурай хүчит тэжээлээр тэжээж байгаа үед малыг хангалттай услаагүйгээс шалтгаалж, сархинаг хатах нь элбэг тохиолдоно. Сархинаг хатсан хонийг гэнэт босгоход явж байгаад байн байн ойчиж, хөлөө дээш харуулан сарваганан хэвтэх шинж тэмдэг үзүүлнэ. Сархинаг хатахаас сэргийлэхийн тулд малаа тогтмол сайн услах нь чухал. Сархинаг хатсан малыг услахаас өмнө давс өгөх, давстай усаар услах нь сайн нөлөөтэй.

11. ЯДАРЧ ДОРОЙТСОН МАЛЫГ СУВИЛАХ ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ ЗАРИМ ЭНГИЙН ЖОРУУД

11.1 ЭНГИЙН ТЭЖЭЭЛ

Өвсний ханд: Сайн чанарын өвсөөр ханд бэлтгэж ядарч доройтсон мал, төл тэжээхэд амархан тэнхэрнэ. Хандлах өвсийг 2—3 см хэрчиж, 8—10 литр буцалсан халуун усанд 300 грамм ногдохоор хийж, дулаан газар 5-8 цаг сайн хучаастай байлгахад ханд бэлэн болно. Бэлэн болсон 1 литр ханданд 10—15 грамм хоолны давс нэмээд бод малд 1.0—1.5 литр, бог малд 150—200 граммаар уулгана. Витаминт өвсний ханд хүрэн бор өнгөтэй, гашуувтар амттай, анхилам үнэртэй байна.

Гурилын зутан: Гурилын зутан бэлтгэхдээ 5-6 литр усанд эсвэл шөлөнд 300-500 грамм гурил самарч буцалгана. Бэлтгэсэн зутанг бод малд 1-2 литр, бог малд 800 граммаар өглөө бэлчээрт гаргахын өмнө өгнө.

Шар будааны зутан: Нэг кг нунтаглаж нүдсэн шар будааг 10 литр хар цай эсвэл 10 литр усанд хийж буцалгаад ядарч доройтсон үхэрт өдөрт 3-4 кг, бяруу, тугалд 500 граммаар өгөхөд түргэн тэнхэрдэг. Мөн хээлтэй хонь, ямаанд төллөхөөс 15 хоногийн өмнө өдөрт 0.5-1 литрийг уулгавал жилбэтэй төллөнө. Жилбэгүй төллөсөн хонинд дээрх хэмжээгээр өгөхөөс гадна нялх төлд нэг литр усанд 200 грамм шар будаа чанаж зутан болгоод амтлагдах төдий элсэн чихэр хийж 30-100 граммаар өдөрт 2-3 удаа өгнө.

Шар будааны шүүс: Нэг литр усанд 200 грамм шар будаа хийж агшаагаад 100 грамм сүү, 1 хоолны халбага элсэн чихэр хийж, дахин бүлээсгээд шүүж богийн төл угжихад сайн тэжээл болдог.

Шар будаа, хивгийн дугуй: Өвөрхангай аймгийн Төгрөг сумын малчид нунтагласан шар будаа 15 хувь, хонины сүүл 30 хувь, хуурсан хивэг 20 хувь, буцалсан ус 30 хувь, хужир давс 5 хувийг хольж хутган 30-40 граммын дугуй хийж өвсөнд орсон төл, хөгшин хонь, ямаанд өдөрт 3 удаа 1 ширхгээр өгдөг байна.

Шар будаа, сонгины үрэл: Өвөрхангай аймгийн малчид 1 ширхэг сонгиныг хэрчиж жижиглээд хоолны халбага давс, нүдсэн нэг аяга шар будаатай багсраад ус, ямар нэг тосоор зуурч 10 грамм орчим жинтэй үрэл хийж, үхэрт өдөрт нэгийг өгдөг.

Сонгино, сармис: Ядарч доройтсон малыг тэнхрүүлэхэд сонгино, сармис сайн чанартай эм болдог. Сонгиныг 2 хуваагаад талыг, сармисны 1 булцууг бог малд өдөрт нэг удаа өгнө. Бод малд үүнээс 2 дахин их хэмжээгээр өгнө.

Сонгины ханд: Зэрлэг болон таримал сонгино нь малын ходоодны шүүс ялгаралтыг ихэсгэж, тэжээл боловсруулах эрхтний үйл ажиллагааг

сайжруулдаг. Сонгины ханд бэлтгэхийн тулд шороо, хальсыг нь цэвэрлэсэн 300 грамм сонгиныг жижиглэн хэрчээд, нэг шанага халуун усанд 1-2 цаг буцалгасны дараа 3-4 давхар марлиар шүүж тугалд өдөрт хоолны халбагаар 3 удаа, хурга ишгэнд 2 удаа өгнө.

Сармисны ханд: Нэг булцуу сармисыг 1 литр халуун усанд хийж, 3-4 цаг буцалгасны дараа бяруу, хонь, ямаанд 3 хоног тутам цайны том халбагаар нэгийг өгөхөд ядарч доройтсон мал амархан тэнхэрнэ.

Чацарганы ханд: Чацарганы витаминт ханд бэлтгэхдээ сайн шахаж няцалсан 100 грамм жимсэнд 500 мл буцалсан халуун ус хийж, дулаан газар 4 цаг байлгана. Ингэж бэлдсэн ханднаасаа хурга, ишгэнд 20 граммыг, бодын төлд 50 граммыг өгдөг.

Цайны шаар: Цайны шаарны 1 литр идээнд 2-3 ширхэг ёотон хийж, өглөө бог малд 250-300 грамм, бод малд 0.5-1 литр хүртэл өгнө. Цайны шаарыг бусад тэжээлтэй хольж хэрэглэж болно. 3-5 ам бүлтэй айлын жилийн турш чанасан цайнаас гурван шуудай шаар гардаг гэдэг. Цайны шаар нь кафейн болон амьтны бие махбодыг тэнхрүүлэх бодис ихтэй учраас цайны шаарыг хог гэж хаялгүй нар, салхинд хатааж хадгалахаас гадна шавхруутай нь хамт хивэг, багсармал, хүчит тэжээлийг дэвтээж ашиглана.

Шар тостой хар цай: Осгож бээрсэн, турж доройтсон малд шар тостой хар цай 100-150 граммаар 30 минутаас 1 цагийн зайтай босч ирэх хүртэл нь өгнө. 10 литр усанд нүдсэн том атга цай хийж сайтар идээшлүүлээд сулхан атга давс, хоолны нэг халбага шар тос хийж сайн самраад халуун бүлээнээр нь бог малд хагас литр, бод малд 2-3 литрийг өгнө. Тарга хүч муутай, тугалласан үнээнд шар тостой өтгөн цай, хиагны мушгиа, витаминт өвс өгч хужир, давстай бүлээн усаар усалбал богино хугацаанд тамир тэнхээ суудаг. Будаа, гурилаар хайрсан өтгөн хар цайг хэт ядарсан малд нэг удаа 200-250 граммаар өдөрт 2 удаа өгөхөд хурдан тэнхэрдэг.

Чихэртэй цай: Нэг литр хар цайнд 30 грамм элсэн чихэр хийж дээр нь хоолны 2 халбага загасны тос нэмж хийнэ. Ингээд төлд 100-150 граммаар 3-4 удаа өгнө. Цайны халуун 35 градус орчим байвал сайн. Тугалд үе үе чихэртэй хар цай өгч байх нь гэдэс ходоодны өвчнөөс сэргийлэх сайн талтай.

Цайны ханд: Аагтай хар цайнд хандны 100 мл тутамд 1-2 грамм давс уусган тугал, ботгонд 100-200 мл, хурга, ишгэнд 25-50 мл-ийг өдөрт 3-4 удаа өгнө.

Хивэг: Хивгийг хуурайгаар, зутагнах, исгэх зэргээр малд өгөхөөс гадна бага зэрэг хуурсан 2 кг хивгийг 1 литр буцлам халуун усаар чийглэж, 3-4 цагийн дараа дангаар нь буюу бусад тэжээлтэй хольж бод малд 1-2 кг, бог малд 300-400 граммыг өдөрт 1 удаа өгөхөд тохиромжтой. Хивэгийн зутан бэлдэхдээ 1 литр усанд 100 грамм хивэг хийж 3 минут буцалгаад зөөгшүүлж

хурга, ишгэнд 100-150 граммаар, тугалд 150-250 граммаар өгнө. Ямар ч малын төлд 1 удаа өгөх чийглэсэн хивгийн хэмжээ жижиг шаазан (50-150 грамм) байж болно. Нэмэгдэл тэжээлд оруулсан бод малд хоногт 2-3 кг, саалийн үнээнд 3-4 кг, бог малд 0.5-0.6 кг хивэг өгч болно.

Уурагжуулсан шингэн тэжээл бэлтгэх: 10 литрийн хувин саванд 40-45 градусын халуун бүлээн ус 5 литр, 2 кг няцалсан будаа, хивэг, хорголжны аль нэгийг хийж зутан болгоно. Зутангийн бүлээн 40 градус болох үед 200 грамм дрожж нэмж, сайтар хутгаад савны амыг таглаж, дулаан газар хучиж, 1-3 цаг тавихад исэж айраг шиг үнэртэй болж анхны хөрөнгө бэлэн болно. Энэ хөрөнгөө цаашид арвижуулан хэрэглэнэ. Тэжээл бэлтгэх 40 литрийн бетон болон түүнтэй төстэй торх саванд 45-50 градусын бүлээн ус 30 литрийг хийж 150 грамм давс нэмж уусгана. Дээрээс нь 4-5 кг хивэг, няцалсан будаа, хорголжин тэжээл хийж зутан бэлтгэнэ. Зутанг 40 градус бүлээн болгох үед 3-4 литр хөрөнгө хийж хутгаад савны амыг таглаж зуух пийшингийн ойролцоо хучиж тавихад 3-4 цагийн дараа иснэ. Иссэний дараа савны амыг онгойлгоно. Хэрэв таглаатай байвал ялзарна. 30-36 градус бүлээнээр бүх төрлийн малд цутгаж өгнө. Хонь, ямаанд 150-200 мл, үхэрт 1-1.5 литрээр хоногт 2-3 удаа, хэт ядарсан малд эхлээд бага багаар өгнө. Жилбэгүй төллөсөн малд 7-10 хоног өгч, дулаан хашаа байранд байлгахад жилбэ сайжирдаг. Сэнсэрсэн хурга, ишгэнд 80-1000 мл-ээр өдөрт 2-3 удаа 3-5 хоног өгч дасгаад цаашид 100-150 мл, тугалд 200-250 мл, бяруунд 350-500 мл-ээр өдөрт 2-3 удаа 10-15 хоног өгнө. Энэ шингэн тэжээлээ малд хувин савнаас уулгаж сургавал хөдөлмөр хөнгөвчилнө.

11.2 АМЬТНЫ ГАРАЛТАЙ ТЭЖЭЭЛ

Сэвс: Малын сэвс нь малын гүзээнд хагас боловсрон уургаар баяжсан байдаг тул малын сайн чанарын тэжээл болдог байна. Хатаасан нэг кг сэвс нь 306 грамм уурагтай тэнцүү шимт чанартай байдаг ажээ. Өвлийн мал нядалгааны үед сэвсийг цуглуулан 200 литрийн багтаамжтай саванд 70%-д нь сэвс, 10% нь хивэг, 10% нь хужир давс, үлдсэн 10%-д нь цус орохоор бодон хольж хийгээд сайтар хутгаж хэвлэн хөлдөөгөөд давхарлан хурааж бэлтгэх бөгөөд бог малд өдөрт 500 граммаар төлд 120 граммаар нэмэгдэл тэжээл болгон хэрэглэнэ.

Малын цус: Нядалгааны үед гарч байгаа малын цусыг цуглуулан 10 кг цусанд 100 грамм давс хийж хуурч хатаан нунтаглан хадгалаад цаг хүндэрсэн үед бог малд өдөрт 50 грамм, бод малд 100 граммаар өгч тэжээнэ.

Тосны гүзээ: Хивэгч малын гүзээ төрөл бүрийн шимт бодисоор баялаг учир шим тэжээлтэй байдаг. Тосны гүзээг жижиглэн хэрчиж төлөг, борлонд бага хэмжээгээр өгч болох бөгөөд махны шөлөнд буцалгаад хөгшин малд өдөрт 250-300 граммыг өгнө. Эсвэл тийм шөлөөр тэжээл багсран өгвөл

сайн байдаг.

Махны шаз: Халдваргүй өвчнөөр хорогдсон малын махыг 1.5-2 цаг чанаж, шөл нь өтгөрч ирэхэд яснаас салган хужир, давс хийж нухаад махны шаз бэлтгэнэ. Хээл нь хүндэрсэн, ядарч доройтсон малд тэжээл өгөхийн өмнө хоолны том халбагаар өдөрт 3 удаа өгөхөд амархан тэнхэрдэг. Мөн махны шазыг хивэг, хужир, таана, адууны элэг, өөхтэй хольж багсраад ядарсан малд өгөх нь илүү үр дүнтэй гэдэг.

Мах, ясны шөл: Мах чанасан шөл уураг өөх, тос, эрдэс бодис элбэгтэй учир ядарч доройтсон, хээл нь томорсон малд сувиллын сайн чанарын тэжээл болдог. Мах чанасан шөлөнд аарц, тосны гүзээ, шар будаа хийж буцалгаад бод малд 400-500 граммаар, бог малд 150-200 граммаар өдөрт 2 удаа өгөх буюу шөлийг дангаар нь бод малд 1-2 литр, бог малд 0.5-0.7 литр, төлөг, борлонд 0.4-0.6 литрийг өглөө бэлчээхийн өмнө бүлээтгэн уулгана. Тостой шөлөөр хүчит болон багсармал нунтаг, тэжээлийг зуурч 50-100 граммаар өнхрүүш бэлтгэж малд өгч болно.

Элэг: Элэг нь уураг, витамин, чихэрлэгийн зүйлээр баялаг учир малыг амархан тэнхрүүлдэг. Элгийг нимгэн зүсэж тостой тогоонд бага зэрэг давс үрээд шүүрхийвтэр хайрч бог малд 30-40 граммаар, бодод 70-100 граммаар, төлд 10-15 граммаар өгнө.

Хатаасан гэдэс: Малын нарийн бүдүүн гэдсийг цэвэрлэж, угаагаад өлгөж хатаана. Хатсан гэдсийг нунтаглаж нүдэж гурил болгоно. 100 мл давстай бүлээн усанд нунтаг гэдэснээс 20-30 граммыг хийж сайн хутгаж холиод хэдэн ч литрийг бэлтгэж болно. Бэлтгэсэн шингэнээс төлөг, борлонд 100-150 мл, тугал бяруу, хонь, ямаанд 150-200 мл, бод малд 500-1000 мл хүртэл хэмжээгээр өдөрт 2 удаа өгч болно. Малын хэл, тархи, дэлүү, сав, булчирхай зэргээр бэлдмэл хийж элэг гэдэсний бэлдмэлийн хэмжээгээр малд өгч болно.

Тархи: Малын дайвар бүх эрхтнээс уураг, төрөл бүрийн шүвтэн хүчлээр баялаг нь тархи учир турж эцсэн малыг тэнхрүүлэхэд хамгийн сайн чанарын сувиллын тэжээл болдог. Халдварт бус өвчнөөр үхсэн малын уураг тархи, нугас эцэж ядраагүй малынхтай найрлага, чанараараа ижил, өөрчлөлтгүй байдаг. Хүнсэндээ хэрэглэсэн эсвэл халдварт бус өвчнөөр хорогдсон малын толгойг чанаж яснаас салгаад бор хальс, мэдрэлийн судсыг ялгаж жижиглэх ба дан тархи нугасаа эврээж нунтаглаад хатааж бод малд 50-60 граммыг, бог малд 20-30 граммыг хоногт нэмэгдэл хэлбэрээр өгнө.

Тархины ханд: 10 литр усанд бог малын тархи 3 ширхгийг жижиглэн хийж 5-6 литр болтол хандлаад хөргөнө. Уг хандаас өдөрт бог малд 100-150 грамм, бод малд 300-400 граммаар бодож өгнө. Цаг зуурын бэрхшээлтэй байсан 1976-1977 оны өвөл ядарч туйлдсан малыг тархины хандаар тэжээж онд оруулсан малчид Хэнтий зэрэг аймагт олон байв. Тураалаар үхсэн, идшинд хэрэглэсэн эрүүл бод, бог малын тархийг малын тэжээлд

хэрэглэж болно.

Адуу, тарваганы өөх: Шингэц, илч сайтай тул ядарч доройтсон малд сайн чанарын тэжээл болдог. Адуу, тарваганы өөхийг хайлж тусгай шил, торхонд хурааж өвөл, хаврын цагт багсармал тэжээлтэй хольж, үнээнд 150-200 грамм, бог малд 50-60 грамм, төлөг борлонд 40-50 граммыг орой хотлуулсны дараа өгнө.

Адууны өөх шар будааны үрэл: Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын малчид адууны өөх 500 грамм, ясны үнс 450 грамм, цагаан давс 100 грамм, шар будааны гурил 450 граммыг хольж хутгаад 1 грамм орчим жинтэй үрэл хийж, төл малыг тэжээдэг байна. Энэ нь хаврын улиралд хурга, ишгийг сэнсрэхээс сэргийлэхэд ач тустай байдаг.

11.3 ЖИЛБЭГҮЙ МАЛЫГ ТЭЖЭЭХ АРГА

Цаг агаарын хүндрэлтэй, цас ихтэй жил мал хэт эцэж турж, бодисын солилцооны дутагдал, орсон үедээ жилбэгүй төллөдөг. Жилбэтэй төллүүлэхийн тулд хээлтэй, тарга хүчээр муу малыг эртнээс нэмэгдэл тэжээлд оруулах хэрэгтэй. Жилбэгүй төллөсөн малыг доорх дарааллаар тэжээж тордоно. Үүнд:

- Юуны өмнө байран тэжээлд оруулж өдөрт 3-4 удаа давстай бүлээн усаар усална.
- Өвсийг тэжээлийн хашаа, сараалжинд хийж байнга идүүлж байхаас гадна хүчит багсармал тэжээлийг буцлам халуун усаар зуурч зутан хийж өгнө.
- Жилбэ оруулахын тулд хэрэглэж байгаа тэжээл нь чанар сайтай, аль болох олон төрлийн байвал тохиромжтой.
- Малын жилбэ оруулахад шар будааг хар цай, шөлөнд чанаж өдөрт 0.5-1 литрээр 2-3 удаа өгөх, бүйлсний буурцаг, хөц, таана, хөмүүл, мангирын зоодой дарш, ногоон өвс, халгайн ханд бэлтгэж өдөрт 2-3 удаа уулгана.
- Хүчит багсармал тэжээлийг зутан болгож өгөх боломжгүй үед сайн дэвтээж, давс хужраар амтлан өдөрт 2-3 удаа өгнө.
- Бог малд өдөрт 0.5-1 кг, бод малд 3-4 кг хүчит багсармал тэжээл өгнө.
- Жилбэгүй төллөсөн малын хоногт идэх тэжээлийн хэмжээ нь байран тэжээлд байгаа малынхтай адил байна. Хэтэрхий бага тэжээл өгвөл жилбэ орохдоо удаан байна.

11.4 ТӨЛ ТЭЖЭЭХ АРГА

Нялх төлийг тэжээхэд юуны өмнө эхийн уураг сүүнд цатгах хэрэгтэй. Уураг сүү бол хялбар шингэж боловсрох, уураг витамин, нүүрс усаар баялаг, төлийн гэдэс дотрыг хар зунгагаас цэвэрлэх, элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх биеийн дархлааг бий болгодог. Төлийн тэжээлийг нялх, хөрвө ба сэнсэрсэн төлийн гэж гурван үндсэн хэсэгт хувааж үзнэ. Үүнд:

- Төлийг эхээс гарснаас хойш цаг, цаг хагасын дараа эхэд нь амлуулна. Амлуулахдаа малын дэлэн хөхийг чийгтэй, цэвэр даавуугаар арчиж эхний хэдэн дусал сүүг сааж хөхний бөглөөг гаргаад амлуулна.
- Нялх төлийг эхтэй нь хамт байлгаж хөрвийн аргаар бойжуулна. Хэрэв эхээс тусгаарлан бойжуулж байгаа бол 3-4 удаа уураг сүүнд нь цадтал хөхүүлж байна.
- Эх нь жилбэгүй төллөсөн бол нялх төлийг ойролцоо хугацаанд төллөсөн өөр малын уураг сүүгээр угжих буюу хөхүүлнэ.
- Олон мал зэрэг жилбэгүй төллөж, сүү дутагдалтай байгаа нөхцөлд хиймэл уураг, хуурай ба өтгөрүүлсэн сүү, сүү орлох тэжээл, сүүнд агшаасан хүүхдийн будаа, шар будаа зэргийг дээр өгүүлсэн аргын дагуу найруулан бэлтгэж өдөрт 3-4 удаа угжина.
- Төлийг долоо хоносноос хойш төлийн байранд навчирхаг ногоон өвсийг тогтмол хэцлэн идүүлж сургах нь чухал. Энэ үеэс эхлэн эрдсийн зоодой, чулуун давсыг байнга тавьж долоолгоно.
- Төлийн байранд хувин саванд цэвэр ус үргэлж байлгаж, уулгаж сургах хэрэгтэй. Усанд бага зэрэг давс нэмбэл амтархан ууж сурна.
- Төлийг хоёр долоо хоногтойгоос нь эхлэн хивэг, няцалсан будаа, багсармал тэжээл зэргийг сайн дэвтээж давс, хужраар амтлан онгоц, хувин саванд хийж идүүлж сургана. Эхлээд нэг хурганд 30-50 грамм орчмыг өгч идэж сурмагц 100 грамм хүртэл нэмэгдүүлнэ.
- Таана хөмлийн зоодой, дарш, агь, шаваг бударганын сорс, ногоон өвс зэргээр ханд бэлтгэн өдөрт 1-2 удаа уулгана. Ингэж тэжээвэл төл амархан махална.

Ходоодны хиймэл шүүс бэлтгэх: Нялх төлийн шүлс, ходоодны шүүсэнд давсны хүчил, маш бага байдаг учир төлийг ойр ойрхон хөхүүлж байхгүй бол хөхсөн уураг, сүүгээ боловсруулж чадахгүй өвчилдөг. Иймд ходоодны хиймэл шүүсийг эрүүл төлд урьдчилан сэргийлэх, өвчтэй төлийг эмчлэх зорилгоор дор дурдсан хэмжээг баримтлан 4-5 хоног өгнө. Хиймэл шүүс бэлтгэхийн тулд 1 литр буцалгасан цэвэр ус, эсвэл нэрмэл усанд 1.19 хувийн жинтэй 5 литр цэвэр давсны хүчил хийж дээр нь 10 грамм пепсин фермент нэмээд сайтар зайлж найруулна. Ийнхүү бэлтгэсэн хиймэл

шүүсийг тугалд 60-100 грамм, хурга, ишгэнд 5-10 граммаар өдөрт нэг удаа хөхүүлэхээс 10-15 минутын өмнө өгнө.

Хиймэл сүү: Хиймэл сүүг хэд хэдэн аргаар бэлтгэж болно. Үүнд:

- 87 грамм хуурай сүү, 5 грамм гурил, 3 грамм давс, 2 грамм загасны тос, 3 грамм элсэн чихрийг 1 литр усанд хольж найруулан бог малын төлд 200-300 грамм, бодын төлд 0.5-1 литрээр өгнө.
- 100 грамм өөхгүй хар махыг машиндаж 1 литр усанд чанаж шүүгээд шөлөнд нь 100 грамм гурил хийж самарна. Дараа нь загасны буюу ургамлын тос 220 грамм, элсэн чихэр 30 грамм, хоолны давс 15 грамм хийж, 0.5-1 цаг болгосны дараа бүлээн болтол хөргөөд биомицин зэрэг антибиотик 0.5 граммыг нэмээд төлд дээрхийн нэгэн адил өгнө.
- 200 грамм цагаан будааг 1.5 литр усанд хийж шалз чанаад бусад зүйлийг дээрхийн адил хольж хэрэглэнэ. 10 литр усанд 250 грамм хүүхдийн будаа хийж, зөөлөн галаар буцалгаад литр тутамд 10 грамм элсэн чихэр, 5 грамм тос нэмнэ. Үүнийг бодын нялх төлд 400-450 грамм, богийн төлд 100 -150 граммаар өдөрт 2 удаа өгнө.
- 10 литр усанд 250 грамм гурил хийж хутган 30 минут буцалгаад литр тутамд 10 грамм элсэн чихэр, 5 грамм загасны тос нэмнэ. Үүнийг бод малын төлд 200-250 грамм, хурга ишгэнд 100-200 грамм өгнө.
- 10 литр усанд 250 грамм хуурч нүдсэн хошуу будаа эсвэл 500 грамм хивэг хийж 1 цаг буцалгаж хөргөөд өтгөн хэсгийг нь шүүж том малд өгөх ба шингэнийг нь бодын төлд 500 грамм, богийн төлд 100 граммыг өгнө.

Төлийн сүү орлох тэжээл: Сүү орлох тэжээлийн жорд улаан буудай 25 хувь, хошуу будаа 25 хувь, шар будаа 20 хувь, арвай 14 хувь, хуурай сүү 10 хувь, шар буурцаг 4 хувь, давс 2 хувь орно. Энэ жороор бэлтгэсэн тэжээл нь өвөл, хаврын цагт жилбэгүй төллөсөн малын төл болон өнчин төлийг угжихад тохиромжтой.

Төлийн тэжээл үйлдвэрлэхэд стандартад тохирсон сайн чанарын үр тариа бэлтгэж элдэв хольцоос цэвэрлэх, арвай, хошуу будааг гүйцэд хальслан хатаах хэрэгтэй. Үр тарианы чанарыг харгалзан нунтаглаж, шигшилтийг хэд дахин хийх шаардлагатай. Савлах, хадгалах, тээвэрлэх явцад тэжээлийг шалан дээр асгах, шороо тоос болгож бохирдуулах, чийгтэй газар удаан хадгалах зэргээс болж тэжээлийн чанар муудна.

Сүү орлох тэжээлийг гар аргаар бэлтгэхдээ юуны өмнө жорын дагуу шаардагдах үр тариа, түүхий эдийг бэлтгэнэ. Үр тариаг сайн хатааж цэвэрлээд гар тээрэм буюу төмөр, модон уураар нунтаглаж, нарийн шигшүүрээр шигшиж гурил хийнэ. Үүний дараа орцын хэмжээг баримтлан хольж, сүү орлох тэжээл бэлтгэнэ. Сүү орлох тэжээлийг 4-5 кг-аар савлаж

бэлтгэх нь зохимжтой. Мал жилбэгүй төллөж байгаа үед сүү орлох тэжээлд сүү, аарц, өндөг, сахар, тос зэргийг бага хэмжээгээр нэмэхэд чанар нь улам сайжирна. Сүү орлох тэжээл 7-гоос дээш хоногийн настай төл тэжээхэд тохиромжтой.

Нэг литр буцалгасан халуун усанд 130-200 грамм сүү орлох тэжээл хийж найруулан сайтар хутгаж бага зэрэг буцалгаад 36-38^oC хэм болтол хөргөж 5-7 хоногтой төлд 100-150 грамм, 7-14 хоногтойд 150-200 граммаар өдөрт 2-3 удаа өгнө. Угжиж байгаа төлийг дулаан байранд байлгаж, хэвтэр бууцыг өдөр тутам хуурайлан сольж байх хэрэгтэй.

Сүү, шар будааны агшаамал: Энэ агшаамлаар төл угжихад зохимжтойгоос гадна жилбэгүй төллөсөн хонь ямаанд өгөхөд сүү орж, ядарч доройтсон өсвөр насны мал тэжээхэд амархан тэнхэрдэг. Сүү сааль элбэгтэй зун, намрын улиралд айл бүр сүү, шар будааны агшаамал тэжээл хүрэлцээтэй бэлтгэж, нөөцлөх явдал төлийг хорогдолгүй бойжуулах, мал сүргийг онд мэнд оруулах чухал нэг нөхцөл мөн. Сүү, шар будааны агшаамалд чийг 5.4 хувь, протейн 20 хувь, тос 12.7 хувь, ислэг 2.6 хувь, азотгүй хандлаг бодис 56.4 хувь, үнс 2.9 хувь байна. Сүү, шар будааны агшаамлыг гашуун амт үнэргүй, шинэ сүүгээр бэлтгэнэ.

Нэг кг будаа агшааж болгоход 3 литр сүү орно. Агшаах будааг цэвэр усаар хоёр удаа зайлж угаагаад тогоонд 6 литр сүү, 2 кг шар будаа хийж зөөлөн галаар агшаана. Будааг түлэхгүйн тулд галаа сайн тохируулах хэрэгтэй. Буцалж эхэлснээс хойш 10-15 минут болоход будаа нь өсөж сүү нь ширгэж эхэлнэ. Агшиж гүйцэж байгаа эсэхийг нь үе үе шалгаж, будаа жигдхэн арзайж зөөлөрсний дараа агшилт гүйцлээ гэж үзэж цог дээр 5 минут загсаах нь зүйтэй. Жигд зөөлөн галаар агшаасан 2 кг будаа бараг тогоо дүүрэн агшаамал болно. Харин агшаах явцад сүү нэмж хийвэл будааны өсөлт зогсох тал байдгийг анхаарах хэрэгтэй. Зөв агшиж гүйцэд болсон будаа хоорондоо наалдаж бөөгнөрөхгүй ширхэг бүтэц нь тодорхой мэдэгддэг. Агшаасны дараа тогоотой нь салхинд тавьж, хусуураар эргүүлэн сийрүүлж 10-15 минут хөргөнө. Хөргөхдөө хооронд нь наалдуулж бөөгнөрүүлэхгүй байхыг хичээнэ. Хөргөсний дараа бөөгнөрснийг нь задалж, дэлгэц дээр жигд нимгэн тарааж хатаана. Хоёр кг будааны агшаамлыг тарааж хатаахад уртаараа нэг метр, өргөнөөрөө хагас метр дэлгэц шаардагдана. Дэлгэцийн хүрээ 3 см байх нь зохимжтой. Дэлгэцэд хийсэн агшаамлыг саравчин тавиур дээр буюу гэр дээр нарны эсрэг талд тавьж салхинд хатаана. Дэлгэц дээр тарааж, нэг цаг болсны дараа агшаамал шаргал өнгөтэй болж эврэх бөгөөд энэ үед будааг хоёр гарын алгаар нитгэрэх буюу эсвэл тусгай үйрүүлэгчээр жижиглэвэл хурдан хатна. Агшаамлыг дутуу хатаавал хөгцөрч муудна.

Сүү, будааны агшаамлыг даавуун уут саванд хийж, нэгээс 2 өдөр салхинд тавьж эргүүлж байгаад гүйцэд хатсаны дараа давхар буюу нягт сав шуудайд 10-15 кг-аар савлаж, ус чийг, шороо тоос орохгүй сэрүүн газар агуулахад газраас хөндий вандан дээр өрж хадгална. Сүү, шар будааны агшаамал нь ялимгүй чийг авбал наалдаж бөөгнөрөн хөгцөрч муудна. Сүү,

шар будааны агшаамлыг тэжээл нунтаглагч машинаар буюу гар аргаар нунтаглана. Сүүнд агшаасан шар будааг малд өгөхдөө нэг литр бүлээн усанд 200 грамм гурил хийж буцалгаад 36-38°C градус болтол хөргөж бог малын төлд өдөрт 300-450 грамм, бод малын төлд 1.5-2 литр өгнө. Ядарч дордсон хонь, ямаанд 0.6-1 литр, өсвөр насны малд 0.5-0.8 литрийг уулгана. Сүү, шар будааны агшаамлыг жилбэгүй мал, ядарч доройтсон төлд нэмэгдэл тэжээлийн журмаар өдөрт 200-300 граммыг өгнө. Жилбэгүй малын төл угжиж, хөрвө төлийг сэнсрэх явдлаас урьдчилан сэргийлж махлуулах зорилгоор хэрэглэх нь сайн үр дүнтэй. Жилбэгүй малын төлийг угжихдаа нэг литр усанд 80-100 грамм агшаамлын гурил хийж самраад дээрээс нь 200-300 грамм сүү нэмж тус бүр нэг халбага элсэн чихэр, хоолны давс уусгаад зөөлөн буцалгаж, бага зэрэг шар тос нэмнэ. 36-38°C градус болтол хөрсний дараа төл угжина.

Хөрвө төл махлуулах зорилгоор хэрэглэхдээ 1.5 литр усанд 100-120 граммыг найруулж, хоолны халбагаар гурил, элсэн чихэр нэмж хийгээд, сайн самарч буцалгана. Ийм тэжээлд адууны болон тарваганы цэвэр тосыг хоолны халбагаар нэмж төл тэжээхэд нэн тохиромжтой.

Бололцоотой газарт тахианы түүхий өндөг, био идэвхжүүлэгч, витамин, антибиотикаар баяжуулан төл тэжээвэл илүү үр дүнтэй болно. Төл тэжээхдээ 3-7 хоногтой нялх төлийг өдөрт 4 удаа, 7-14 хоносныг 3 удаа, 14-өөс дээш хоногтой төлийг 2 удаа угжина. Төлд нэг удаа өгөх тэжээлийн хэмжээ нь 3-7 хоногтойд 70-120 грамм, 7-14 хоногтойд 150-250 грамм, 14-өөс дээш хоногтойд 250-300 грамм байна. Угжны төлийг нялх үед нь элгэвч зүүж, дэвсгэрийг байнга хуурай байлгах нь чухал.

Төл угжих багсармал тэжээл: Энэ тэжээл нь төлийн өсөж торних шаардлагыг хангаж чадахуйц хэмжээний уураг, витамин, эрдэс бодистой байна. Төл угжих нэг кг багсармал тэжээл бэлтгэхэд сүү 100 грамм, 2 дугаар гурил 100 грамм, шар будаа 190 грамм, арвай 200 грамм, хошуу будаа 200 грамм, хивэг 200 грамм, давс 10 грамм орно. Түүнийг үйлдвэрийн аргаар бэлтгэхээс гадна аж ахуйдаа буюу малчид өөрсдөө бэлтгэж болно. Арвай, хошуу будаа, хивгийг гар тээрэм, уур, нүдүүрээр няцалж тээрэмдсэний дараа нарийн шигшүүр буюу марлиар шигшихэд, нэг кг хошуу будаанаас 500-700 грамм, арвайгаас 800-900 грамм гурил гарна. Уг гурилыг дээрх жорын дагуу хуурай сүү, гурил, давстай маш сайн хольж төл угжих багсармал тэжээл бэлтгэнэ. Төл угжих багсармал тэжээлийг нэг литр усанд 100-150 грамм оногдохоор бодож найруулан огцом түргэн буцалгаж, бүлээн болтол хөргөөд жилбэгүй төллөсөн бог малын төлийг өдөрт 2-3 удаа 100-150 граммаар угжиж цаашид дасгах журмаар 200-250 грамм хүртэл нэмэгдүүлнэ. Энэ тэжээлээр угжиж байгаа төлийг даарч хөрөхөөс болгоомжлон элгэвчтэй байлгавал зохино. Төл угжих багсармал тэжээл бэлтгэхэд гарсан үр тарианы үлдэгдлийг дэвтээх буюу исгэж турж доройтсон малын тэжээлд ашиглана.

Хошуу будааны зутан: Энэ нь төлийн гэдэс ходоодны ажиллагааг

сайжруулахаас гадна өвчилсөн ба ядарч доройтсон төлийг түргэн тэнхрүүлж махлуулдаг. Зутан бэлтгэхдээ сайн чанарын хошуу будааг дутуу хуурч тээрэмдэж гурил болгоно. Нэг кг хошуу будааны гурил дээр 2.5 литр буцалгасан ус хийж сайтар хутгаад хөргөнө. Дараа нь шингэнийг шүүж литр тутамд 5 грамм хоолны давс хийж, зутан болтол буцалгаад 30-35 хэмийн бүлээнээр нь төлд өгнө. Бэлтгэсэн зутанг хонуулалгүй өдөрт нь хэрэглэж дуусгана. Хошуу будааны зутан бэлтгэхэд гарах өтгөн хэсгийг ядарч доройтсон, төллөсөн малд өгнө. Зутангаар төл тэжээхдээ 12-15 хоногтойд 50-60 грамм, 16-18 хоногтойд 200 грамм, 19-21 хоногтойд 300 грамм, 22-23 хоногтойд 420 грамм, 24-28 хоногоос дээш сарын настайд нь 500 граммаар өгнө.

11.5 ХӨРВӨЖСӨН ТӨЛИЙГ ТЭЖЭЭХ

Хавар цас хайлж ус хомсдох болон бэлчээрийн өвс улам хатаж, шимт чанар нь бууран, малын сүү шим татарч төлөө цатгахгүй болж ирнэ. Энэ үед хөрвөжсөн төлийг сайн тэжээж байх хэрэгтэй. Хөрвөжсөн төл, өвс, хүчит багсармал тэжээлд бүрэн орсон байх тул тэдгээрийг эхээс ялган хотонд үлдээж тэжээнэ.

- Төлд ногоон өвсийг дураар идүүлж байхын тулд өвсийг сараалжинд хийж байнга дүүргэж байлгана. Зун ургамал цэцэглэх үед хадаж бэлтгэсэн витаминт өвсөөр төл тэжээхэд хамгийн тохиромжтой.
- Бог малын төлд 100-150 грамм, бод малын төлд 200-300 грамм хүчит, багсармал тэжээл оногдохоор бодож нийт төлд өгөх тэжээлийг урьдчилан сайн дэвтээж бэлтгэнэ. Хивгийг чийглэж пургихгүй болгоод үд дундын алдад онгоцонд хийж байранд нь



тавина.

- Эрдэс тэжээлийг онгоц буюу хувин саванд хийх, дүүжлэх замаар байнга долоолгож байна.
- Цэвэр бүлээн усаар өдөрт 1-2 удаа тогтмол услах буюу байранд нь үргэлж устай байлгаж, дуртай цагтаа ууж байх бололцоогоор хангана.
- Хавар өдөр уртасч дулаан болж бэлчээрийн цас ханзарсан үед хөрвө төлийг өдрийн цагт 3-4 цаг ойрын бэлчээрт бэлчээнэ.

Ногоонд бүрэн цадтал нь ингэж тэжээж чадвал төлийг сэнсрүүлэхгүй. Сэнсэрсэн төлийг тэжээж тэнхрүүлэх явдал хамгийн чухал байдаг. Хавар цас ханзарч дулаан болох үеэр хөрвөжсөн төлийг эхтэй нь хамт бэлчээснээс хурга, ишиг том малын явдлыг гүйцэхгүй өдөржин бэлчээрт дагаж гүйснээс болж сэнсэрдэг. Төл мал хэдийгээр хөрвөжин өвс тэжээл идэж чаддаг болсон ч бэлчээрийн ислэг ихтэй хагд өвсийг бүрэн сайн боловсруулан шингээж чадахгүй. Иймээс төлд өдөр бүр үзлэг хийж сэнсрэх шинжтэй хэсгийг ялган бэлчээрт гаргалгүй хотонд үлдээж, ногоон өвс, хүчит багсармал тэжээлээр тэжээж тордоно. Сэнсэрсэн төлд уураг, витаминаар баялаг тэжээл өгч хурдан тэнхрүүлэх шаардлагатай байдаг. Ийм тэжээлд гурилын хивэг, шар будаа, вандуй, аарцны ханд болон таана хөмлийн дарш, зоодой, сорс, халгай, витаминт өвс, нарсны шилмүүс зэргийг хандалж өдөрт 1-2 удаа өгөхөөс гадна хүчит, багсармал тэжээлийн зутан хийж өгвөл төл амархан тэнхэрнэ.

11.6 ОРОН НУТГИЙН НӨӨЦ АШИГЛАЖ ГАР ТЭЖЭЭЛ БЭЛТГЭХ

Байгалийн хадлан бэлтгэх нь малчдын маань бэлтгэж ирсэн тэжээлийн гол төрөл юм. Хадлан бэлтгэх технологи нь энгийн, төвөг багатай ажил юм. Өнөөдөр нийт бэлтгэж байгаа тэжээлийн 65 хувийг хадлангийн өвс эзэлж байна. Ойт хээрийн бүсэд хадлан бэлтгэх зохистой хугацаа нь долдугаар сарын сүүлчээс наймдугаар сарын төгсгөл хүртэлх 30-35 хоног байдаг. Хэрэв дурдсан хугацаанаас эрт эсвэл оройтож хадвал га тутмаас 4.6-7.8 ц/га өвс авах боломжийг алддаг. Харин хадланд 3 талбай бүхий 3 жилийн сэлгээг нэвтрүүлэх нь ургамал_өсөлт хөгжилтөө хэвийн явуулж нөхөн сэргэлтдээ шаардагдах нөөц тэжээлийн бодисыг хуримтлуулах боломж олгон улмаар хадлангийн талбайг доройтолд оруулахгүйгээр олон жил ашиглах нөхцөл бүрдүүлдэг.

Таана, хөмүүлийн зоодой: Зургадугаар сарын 15-наас наймдугаар сарын 20 хүртэлх хугацаанд таана, хөмүүл түүж хэрчих буюу махны машинаар машиндаж шүүсэнд нь давс, аарцтай базаж зоодойлно. Эсвэл хоёр шанага таананд 200-250 грамм гурил буюу хивэг, аарц, 5-6 хоолны халбага нунтаг давс буюу хужир хийж 20-50 граммын хэмжээтэй дугуй зоодой хийж сүүдэрт хатаана. Ингэж бэлтгэсэн зоодойг хуурайгаар нь буюу

халуун усанд хийж хандалж өгөхөөс гадна өвс, сүрэл бусад тэжээлтэй хольж өгвөл мал тэжээлд амархан орно.

Халгай: Халгайг ургаж эхлэх үеэс нь наймдугаар сарын дунд үе хүртэл хугацаанд гар хадуураар хадах буюу намхан тачир үед нь хайчилж аваад витаминт шимт тэжээл бэлтгэнэ. Дөнгөж ургаж байгаа халгайг түүж хэрчээд нэг кг тутамд 10-20 грамм давс буюу хужир, 100-150 грамм хивэг хийж янз бүрийн хэлбэртэй хэвэнд нягт шахаж сүүдэрт хатаана. Мөн халгайг хэрчиж жижиглээд сүүдэр газар дэлгэж хатаана. Ингэж бэлдсэн 2 кг халгай тутамд 10 литр ус хийж 30 минут орчим буцалгаж таглан 1-2 цаг хучиж дулаан байлгасны дараа марлиар хандыг шүүнэ. Халгайн ханданд хоолны давс нэмж уусгаад хурга ишгэнд 30-50 грамм, унага, тугалд 50-100 граммаар өдөрт 3-4 удаа өгнө.

Агийн ханд: Агь нь уураг, тослог, ихтэй тэжээлийн сайн чанарын ургамал юм. Агийг долоо болон наймдугаар сард хураан авч ногооноор нь хатаана. Ханд хийхдээ 10 литр усанд хоёр дундын шаазан буюу 200-300 грамм хэрчиж жижиглэсэн агь хийж хүрэн, бор өнгөтэй болтол буцалгаж хандална. Турж эцсэн хонь ямаанд өдөрт 0.5-1 литрийг өгөхөд амархан тэнхэрнэ.

Мангирын сорс: Мангирын сорсыг есдүгээр сард бэлтгэнэ. Мангирыг түүж жижиглэн хэрчээд аарцтай хольж, 10 кг-д 0.5 кг орчим нунтаг давс хийж гүзээ, туламд даршилж болно. Халуун усанд хандалсан сорсыг жилбэ муутай буюу ядарсан төлөг борлонд хоолны халбагаар өдөрт нэг удаа өгнө.

Модны навч: Хус, улиас, хайлаас, бургас, бүйлс, зэрэг навчит модны навчийг шарлаж унасны дараа шуудайлан хадгалж малын тэжээлд нөөцөлнө. Навчийг малд өгөх өвсний 20-30 хувьд оролцуулан урьдчилан бүлээн усанд дэвтээсний дараа өгнө.

Үртэс, хомоолтой холимог тэжээл: 100 кг холимог тэжээл бэлтгэхийн тулд 21 кг модны үртэс, 25 кг хивэг, 46 кг улаан буудай, 8 кг адууны халтар хомоолыг нунтаглаад сайтар холино. Өвөл, хаврын улиралд мал бэлчээрээс ирсний дараа холимог тэжээлийг үхэрт 2.5-3.0 кг, хонь, ямаанд 200-300 граммыг бага зэрэг чийглэж өгнө.

Шахмал тэжээл: Ясны гурил, үнс, давс, модны холтос зэргийг өвстэй хольж шар сүү, аарц, цус зэргээр зуурч бэлтгэнэ. Үүнд: 10 литр цус эсвэл шар сүү, эсвэл аарцанд ясны гурил 500 грамм, хужир гурил тус бүр 100 граммыг хольж буцалгаад дээр нь 1 кг давс хийж тоосго шиг шахна. Ингэхдээ шахмалын голд нүх гаргаж хатахаар нь модонд өлгөж малд өгнө. Дээрх аргаар бэлтгэсэн тэжээлийг шахахгүйгээр багсармал тэжээл маягаар бэлтгэн ядарч доройтсон малд хавар өгөхөд амархан тэнхэрнэ. Ийм тэжээлийн нойтон байх үеийн жин хатахдаа 4 дахин бага болно.

Өвсний ханд бэлтгэх: Үүний тулд өвсийг 2-3 см урттай хэрчиж жижиглэн хувин саванд хийж 1 кг тутамд 6-8 литр ус хийж дулаан газар 5-6 цаг байлгана. Бэлэн болсон хандыг шүүн 1 литр тутамд 10-15 грамм хоолны давс нэмээд ядарч доройтсон бод малд 1-2 литр, богд 150-200 мл-ийг өгнө.

12. ХОРОГДСОН МАЛЫН СЭГ ЗЭМ УСТГАХ ЗӨВЛӨМЖ

Зудын улмаас олон тоогоор хорогдсон малын сэг зэм нь хүрээлэн буй орчин, малын бэлчээр, ундны ус бохирдуулж, олон төрлийн өвчин гарах, өвчин тарах талбар болж, хүн, малын эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх тул хаврын цагт цаг агаар хэт дулаарахаас урьтаж зохих зааврын дагуу устгана. Хорогдсон малын сэг зэм устгалыг булах, шатаах аргаар гүйцэтгэнэ.

Булах: Малын хашаа байр саравчнаас 100-аас доошгүй метрийн зайд, үерийн усанд автахааргүй газрыг сонгон авч 2 метрээс доошгүй гүн нүх ухаж, хорогдсон малын сэг зэмийг булна. Эхлээд нүхний ёроолд хуурай халдваргүйжүүлэлтийн бодис хийж, сэг зэм, үнс хийсний дараа дахин халдваргүйжүүлэлтийн бодис цацаж, байгалийн шороогоор дарах байдлаар гүйцэтгэнэ. Шатаах аргаар устгал хийсэн үед үнс, бусад үлдэгдлийг мөн бэлтгэсэн нүхэнд булшилна.

Шатаах: 2 метрээс доошгүй гүн ухсан нүхний ёроолд сүрэл дэвсэж, сэг зэмийг нүхний дунд хэсэг хүртэл хийж шатаах хэрэгслээр дүүргэж шатаана. Хүүр сэг зэмийг шатаах үед гал түймэр гарахаас сэргийлж, шороо болон бусад зүйлээр хаалт хийнэ.

Анхааруулга: Сэг зэмийг булшилсан газар буюу цэгт хайс, хашаагаар хамгаалалт хийх, чулуугаар дарж, ойролцоо цэгт анхааруулах самбар (50 см-ийн өргөн, 60 см-ийн урттай, 2 метрээс багагүй өндөртэй, улаан өнгийн будгаар бичсэн АНХААР “Хүн мал оруулахыг хориглоно” гэсэн бичвэртэй) байрлуулж, орон нутгийн засаг захиргаа, мэргэжлийн байгууллагын хяналтад авч байршил тогтоогч (GPS)-оор бүртгэлжүүлнэ. Хорогдсон малын сэг зэмийг булшилсан газар буюу цэгийг аймаг, сумын Засаг даргын тамгын газрын хяналтад 3 жил байлгаж, хүн, мал оруулах, үйлдвэрийн болон ахуйн зориулалтаар ашиглахыг хориглоно.

Ариутгал халдваргүйжүүлэлт: Сэг зэмийг тээвэрлэж, устгалын цэгт хүргэх авто тээврийн хэрэгслийн ачих хэсэг нь ус нэвтрэхгүйгээр битүүмжлэгдсэн байна. Хорогдсон малын сэг зэм цуглуулж, булах устгах ажилд оролцох хүмүүс хамгаалалтын хувцас хэрэгслээр бүрэн хангагдсан байх ба ажил дууссаны дараа хувцас, биеийн ил хэсэг болон тээврийн хэрэгсэл, хашаа хороо, хэвтэр бууц, тэжээл, уст цэгийн орчмыг зөвшөөрөгдсөн бодисоор халдваргүйжүүлнэ. Шаардлагатай гэж үзвэл хамгаалах хэрэгсэл, хувцсыг устгана.